



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.09.17 № 60

Хууль зүй, дотоод хэргийн салбарын үйл
ажиллагаатай холбоотой асуудлаар

Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан иргэнд хэрэг үүсгэж, ял наймаалцахыг завдсан гэх агуулгатай мэдээлэл, бичлэг олон нийтийн сүлжээнд тархсантай холбогдуулан 2026 оны 9 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга А.Намсаманд нар салбарын удирдлага, үйл ажиллагаатай холбоотой харилцан зөрүүтэй мэдээллийг олон нийтэд мэдээлсэн.

Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын удирдах албан тушаалтны томилгоонд нөлөөлсөн, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон, хууль бус тушаал, чиглэл өгсөн, мөн тус байгууллагын төсөв, хөрөнгө, хоригдлын хөдөлмөр, уурхайн талбай, төсвийн шилжүүлэгтэй холбоотой зөрчил гаргасан, төрийн цэргийн байгууллага болон хорих ангиудыг дайчлан төрийн эрх мэдлийг хууль бусаар авахыг завдсан, иргэдэд хууль бусаар гүйцэтгэх ажиллагаа явуулсан, тагнаж, чагнасан гэх асуудлуудыг тус тус хөндсөн.

Эдгээр асуудал нь хууль сахиулах байгууллагын хууль ёсны, хараат бус үйл ажиллагаа, төрийн албаны томилгоо, төрийн санхүү, нийтийн өмчийн ашиглалт, хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, төрийн эрх мэдлийг хууль бусаар авахтай холбоотой ноцтой асуудлууд байж болзошгүй тул бодит нөхцөл байдлыг албан ёсны мэдээлэл, баримтад үндэслэн тодруулах шаардлагатай гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд дараах асуултыг тавьж байна.

1.Хууль зүй, дотоод хэргийн сайд иргэнд хэрэг үүсгэж, цагдаагийн алба хаагчаар дамжуулан дарамт үзүүлэх замаар ял наймаалцахыг завдсан байж болзошгүй гэх мэдээлэл, олон нийтэд тархсан бичлэгтэй холбогдуулан эрх бүхий байгууллагаас шалгалт, мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлсэн эсэх, эхлүүлсэн бол түүний эрх зүйн үндэслэл, хамрах хүрээ, эхэлсэн огноо, хариуцан явуулж байгаа байгууллага, шалгалтын хугацаа, явц болон гарсан шийдвэрийн талаарх мэдээлэл;

2.Цэргийн болон хорих байгууллагыг дайчлан төрийн эсрэг хууль бус үйл ажиллагаа явуулсан, төрийн эрх мэдлийг хууль бусаар авахыг завдсан гэх мэдээлэлтэй холбогдуулан ийм нөхцөл байдал тогтоогдсон эсэх, тогтоогдсон бол уг ажиллагааг хэн, ямар зорилгоор, ямар эрх зүйн үндэслэлээр зохион байгуулсан, ямар байгууллага, албан тушаалтан оролцсон, холбогдох

2026000176

эрх бүхий байгууллагаас ямар арга хэмжээ авсан, хяналт шалгалтын дүн болон хариуцлага тооцсон эсэх талаарх мэдээлэл;

3.Иргэдэд хууль бусаар гүйцэтгэх ажиллагаа явуулсан, тагнасан, чагнасан гэх мэдээлэлтэй холбогдуулан ийм тохиолдол тогтоогдсон эсэх, тогтоогдсон бол тухайн ажиллагааг хэн, ямар эрх зүйн үндэслэл, зөвшөөрлөөр явуулсан, хуульд заасан зөвшөөрөл, хяналтын горим мөрдөгдсөн эсэх, уг асуудлаар дотоод болон бусад хяналт шалгалт хийсэн эсэх, хийсэн бол түүний дүн, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцсон эсэх талаарх мэдээлэл;

4.Хууль зүй, дотоод хэргийн сайд болон тус яамны удирдах албан тушаалтнаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын удирдах албан тушаалд тодорхой иргэнийг томилох, чөлөөлөх, шилжүүлэх талаар санал, үүрэг, чиглэл өгсөн эсэх, ийм тохиолдол байгаа бол тухайн санал, үүрэг, чиглэлийн эрх зүйн үндэслэл, холбогдох албан бичиг, тушаал, шийдвэр болон тухайн иргэн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан эсэх талаарх мэдээлэл;

5.Хууль зүй, дотоод хэргийн сайд болон тус яамны удирдах албан тушаалтнаас тодорхой иргэн, хуулийн этгээдтэй холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэхгүй байх, зогсоох, хойшлуулах, өөрчлөх, эсхүл хууль, журмын бус аливаа шийдвэр гаргуулах талаар үүрэг, чиглэл, хүсэлт өгсөн эсэх, ийм тохиолдол байгаа бол тухайн ажиллагаа, оролцсон албан тушаалтан, үүрэг, чиглэл, хүсэлтийн хэлбэр, эрх зүйн үндэслэл болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл;

6.Цагдаагийн байгууллагын орон тоо, алба хаагчдын цалин, урамшуулалд зориулсан төсвийн 7,9 тэрбум төгрөгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт шилжүүлсэн гэх мэдээлэл үнэн эсэх, шилжүүлсэн бол уг шийдвэрийг гаргасан байгууллага, албан тушаалтан, шийдвэрийн огноо, эрх зүйн үндэслэл, мөн уг төсвийн гүйцэтгэл болон холбогдох шийдвэр, баримт бичгийн талаарх мэдээлэл;

7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын төсөв, төрийн өмч, хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, удирдлага болон алба хаагчдад хууль, журмын үндэслэлгүй мөнгөн олголт, урамшуулал олгосон гэх мэдээлэлтэй холбогдуулан аудит, санхүүгийн болон дотоод хяналт шалгалт хийсэн эсэх, хийсэн бол түүний хамрах хугацаа, мөнгөн дүн, илэрсэн зөрчил, тавьсан акт, албан шаардлага, төлбөр барагдуулалт болон хариуцлага тооцсон эсэх талаарх мэдээлэл;

8.Хорих ял эдэлж байгаа хүний хөдөлмөрийг хуульд заасан зориулалт, журмаас өөрөөр албан тушаалтан болон бусад этгээдийн хувийн өмчийн барилга байгууламж, объектод ашигласан гэх мэдээллийг шалгасан эсэх, ийм тохиолдол тогтоогдсон бол ямар эрх зүйн үндэслэл, гэрээ, шийдвэрээр, ямар хугацаанд, хэдэн хүнийг, ямар ажилд оролцуулсан, хөдөлмөрийн хөлс болон холбогдох төлбөр тооцоог хэрхэн шийдвэрлэсэн, уг үйл ажиллагаанд оролцсон болон шийдвэр гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцсон эсэх талаарх мэдээлэл;

9.Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 304 дүгээр тогтоолоор Ашигт малтмал, газрын тосны газарт буцаан өгөхөөр шийдвэрлэсэн Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын “Нүүрстэйн ам” нэртэй 83 га, Төв аймгийн Лүн сумын “Авдрант” нэртэй 31 га уурхайн талбай болон тэдгээрийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн өнөөгийн эрх зүйн статус, эдгээр талбай, тусгай зөвшөөрлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон түүний харьяа байгууллагын мэдэлд буцаан авах, үйл ажиллагааг сэргээх, ашиглах талаар Засгийн газар, яам, агентлагийн түвшинд шийдвэр гарсан эсэх, хоёр байгууллагын хооронд эрх зүйн хүчин төгөлдөр баримт бичиг үйлдэгдсэн эсэх, энэ чиглэлээр бусад ажиллагаа явагдсан эсэх талаарх мэдээлэл;

10.Дээр дурдсан асуудлуудаас хууль тогтоомж зөрчсөн, сахилгын, зөрчлийн болон гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл тогтоогдсон бол холбогдох асуудлыг ямар эрх бүхий байгууллагад, хэзээ шилжүүлсэн, ямар шийдвэр гарсан, ямар хариуцлага тооцсон, мөн цаашид хууль сахиулах болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хууль ёсны, хараат бус үйл ажиллагааг хангах, ижил төрлийн зөрчил дахин гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээлэл.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ж.БАЯРМАА

2028000176